

## Монгол-Польшийн харилцаа (1950-1990)

К.Дэмбэрэл<sup>1</sup>

*Энэхүү өгүүлэлд БНМАУ, БНПАУ-ын харилцааны чухал үе болох 1950-1990 онуудад хоёр талууд харилцаагаа хэрхэн өргөжиж тэлснийг харууллаа. Өгүүлэл нь архивын материалд тулгуурлан социалист системийн хоёр орны харилцааны бүхий л хүрээг дэлгэн харуулсан. Энэ судалгаа нь социалист системийн орнуудын өргөн харилцааг судлан нийтэд хүргэх аргачлалыг тусгав. Өнөөгийн Монгол, Польшийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх үндэс нь хангалттай байгааг энэхүү өгүүлэл харуулж байна.*

*This article aims to vividly describe the relations between the two "People's Republics" during the period of 1950-1990 - the main cycle which rendered particular support to enrich the bilateral relations. The Mongolian People's Republic and the Polish People's Republic used to cooperate in almost all sectors including politics, economics, trade, culture, education, science, tourism, health, agriculture and defence.*

*This article about the relations of the two countries was written based on the materials and other research papers of the central archive of Foreign Ministry of Mongolia and documentary centre of MPRP.*

**Түлхүүр үгс:** БНМАУ, БНПАУ, МПНН, ЭЗХТЗ, Ю.Цэдэнбал, В.Ярузельски

---

<sup>1</sup>ШУА-ийн ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан и-мэйл: demberelkolya@yahoo.com

## ОЛОН УЛС СУДЛАЛ

\* \* \*



“Bohater”-баатар, “Ulan”-улаан, “Arhan”-аргамж, “Tumen”-түмэн гэх мэтээр монгол хэлнээс гаралтай польш үгс<sup>2</sup>, бүхэл бүтэн нь тосгон нь “Монголица” нэрээр нэрлэгдэн хоцорсон зэрэг нь хоёр улсын харилцааг нэлээн эртний түүхтэйг гэрчлэх ч бидний харилцаа “баялаг түүхтэй” гэсэн үг бас биш. Энэхүү судалгаанд “баялаг бус харилцааг” баяжуулахад зохих дэм үзүүлсэн мөчлөг болох 1950-1990 оны үеийн “Ардын Бүгд Найрамдах” хэмээх хоёр улсын харилцааг авч үзлээ.

Энэ үед монголчууд, польшууд бие биенээ “мэддэг”, газрын зураг дээр улсуудаа олоод заачих, тэр бүү хэл төрийн тэргүүн нарынхаа овог нэрийг бүтнээр нь хэлчих хэмжээнд хүрсэн. БНМАУ, БНПАУ нь улс төр, эдийн засаг, худалдаа, соёл боловсрол, шинжлэх ухаан, аялал жуулчлал, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, батлан хамгаалах зэргээр “хамтраагүй” салбар бараг ховор байсан үе. Хоёр орны хооронд эмэгтэйчүүд, эвлэл, пионер, үйлдвэрчин, залуучууд, оюутан, соёл урлагийн төлөөлөл, хэвлэл мэдээлэл, радио телевиз, аялал жуулчлал, хувсгалт тэмцлийн ахмад зүтгэлтнүүдийн холбоо, дунд сургуулиудын шефийн холбоо, хотуудын хамтын ажиллагаа зэргээр өргөн харилцааг чухам энэ үед л бий болгосон.

Зүүн Европын “ардын ардчилсан” орнуудтай тогтоосон дипломат харилцаа нь БНМАУ-ын гадаад бодлогод тэлэлт бий болгож “юмыг бага ч гэсэн өөрөөр харах”, “нүд нээгдэхэд”<sup>3</sup> төдийгүй европын соёл, иргэншилд “явж ороход” түлхэц болжээ. Манай гадаад бодлого нь ЗХУ болон Зүүн Европын социалист орнуудын хувьд “найрамдах”, “нөхөрлөх”, “ойртон нягтрах” лоозонгийн хүрээнд баригдмал байлаа”<sup>4</sup> гэсэн судлаачдын дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхийн хамт энэхүү “өргөн харилцаа нь” монголчууд, польшуудын хувьд түүнчлэн БНМАУ, БНПАУ гэсэн олон улсын харилцааны хоёр субъектын хувьд “ямар ач холбогдолтой байв” гэдгийг архивын баримтад тулгуурлан энэ судалгаандаа дүгнэхийг оролдлоо. Монголын нийт 27 яам, тусгай

<sup>2</sup>Гадаад харилцааны төв архив. х-7, д-01, хн-17.

<sup>3</sup> Монгол улсын гадаад харилцааны зуун жилийн түүхийн тойм 1911-2011. УБ., 2011. тал 187

<sup>4</sup> Мөн тэнд 205

газар, олон нийтийн байгууллага польшийн холбогдох яам, газруудтай шууд харилцаатай ажиллаж байв. Дотоод эрх мэдэл, олон харилцааны асуудлаар эдгээр субъектуудын хоорондын харилцаа нь “харьцангуй тэгш эрхтэй” харилцаа байж чадсан.

### **Улс төрийн харилцаа**

БНМАУ нь Москва дахь ЭСЯ-аараа дамжуулан хөөцөлдөж 1950 оны 4 сарын 14-нд Монгол-Польш хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоож 1951 онд ардын хувьсгалын 30 жилийн ойд Польшийн эрүүл мэндийн сайд 2 хүний хамтаар оролцсон нь дээд зиндааны анхны албаны хүн байсан болов уу. 1954 онд ПАНН-ын ТХ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга Болеслав Берут Улаанбаатар хотод нэг өдрийн айлчлал хийсэн. Энэ үеэс эхэлсэн өндөр хэмжээний айлчлал 40 жилийн хугацаанд эдийн засгийн талд “далайц багатай” харилцаатай хоёр улсын хувьд давтамж, зиндааны хувьд “өргөн” байж чадсан.

1955 онд БНПАУ-ын 10 жилийн ойн баярын үйл ажиллагаанд Ю.Цэдэнбал тэргүүтэй төлөөлөгчид оролцсон. 1957 оны 9 сард МАХН-ын ТХ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал тэргүүтэй төлөөлөгчид (Ю.Цэдэнбал даргын төрсөн өдрөөр) БНПАУ-ын нам, засгийн тэргүүн В.Гомулка, Ю.Циранкевич нартай албан хэлэлцээ хийсэн байдаг.

Польшуудын хувьд манайхныг хүлээн авахдаа нам, төрийн дээд удирдлагууд нь өөрийн биеэр тосох, агаарын хил дээр онгоцоор тосох зэргээр өндөр хүндэтгэл үзүүлдэг байсан ч заримдаа дотоод нөхцөл байдлын улмаас Монголд айлчлах урилгаа 10 жилээр ч “царцаадаг” байлаа. Эдгээр айлчлалаар БНМАУ-ын бүтээн байгуулалт, хоёр орны худалдаанд дэмжлэг болсон олон хэлэлцээр, гэрээнүүд хийгдсэн.

1968 оны 9 сарын 20-25-нд Төрийн Зөвлөлийн дарга М.Спыхальски БНМАУ-д төрийн айлчлал хийхдээ монголчуудын хувьд үндэсний зан заншлаа хэвээр хадгалж байгаад талархаад “БНМАУ-д Зүүн Европын социалист орнууд дангаараа бус Эдийн Засгийн Харилцан Туслах Зөвлөлийн (ЭЗХТЗ) хүрээнд нэгдсэн шугамаар бүтээн байгуулалт

## ОЛОН УЛС СУДЛАЛ

хийвэл илүү үр дүнтэй болно”<sup>5</sup> хэмээн тэмдэглэжээ. 1972 онд БНПАУ-ын ГЯЯ-ны сайд С.Ольшовски айлчлалын үеэр “БНМАУ, БНПАУ-ын Найрамдал, хамтын ажиллагааны гэрээ”-г үзэглэсэн ба тэр гэрээ нь 1975 оны 7 сард БНПАУ-ын Төрийн Зөвлөлийн дарга Г.Яблоньскийн айлчлалын үеэр батлагдсан. Энэхүү гэрээ нь дипломат харилцаа тогтоосноос хойшхи 25 жилийн босгон дээр батлагдан хоёр орны хоорондын найрамдал, хамтын ажиллагааны тухай анхны гэрээ байж хоёр талын эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагаа болон Засгийн газар хоорондын хамтарсан Комиссын үйл ажиллагааг нь цаашид сайжруулахад чиглэгдсэн. МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ж.Батмөнх 1988 оны 10 сард БНПАУ-д албан ёсны айлчлал хийх үед БНПАУ-ын төрийн тэргүүн В.Ярузельски “... өөрчлөн байгуулалт хийхэд нэг загвар байж таарахгүй. ЗХУ-ын туршлага их хэрэгтэй. Өөр өөрийн түүхэн онцлогт тохирсон өөрчлөн байгуулалтыг хийх ёстой”<sup>6</sup> хэмээн социалист системийн задралын төгсгөлд өөрийн байр сууриа илэрхийлсэн байдаг.

1959 онд БНМАУ-ын ЭСЯ-ыг Варшавт, 1960 онд БНПАУ-ын ЭСЯ-ыг Улаанбаатарт харилцан нээлээ. Варшав дахь Монголын ЭСЯ нь Өрнөдийн зарим орныг давхар хариуцаж байлаа. БНПАУ-ын ГЯЯ-ны II департамент нь Азийн орнуудыг хариуцан дотор нь монгол, хятад, солонгосын тасагтай байж ГЯЯ-ны орлогч сайд нь “монголын асуудлыг” хариуцан ажиллаж байв. Польшийн ГЯЯ-ны бүх шатны ажилтнууд манай ЭСЯ-ны ажилтнуудад маш эелдэг харилцаж “бүх талаар тусалж дэмждэг, хүсэлтийг маш шуурхай гүйцэтгэдэг байлаа” хэмээн манай ЭСЯ-ны тайланд өгүүлжээ.

1950-1970 онуудад хоёр орны хооронд дараахи хэлэлцээрүүд байгуулагдсан байлаа.

- Радиогийн байгууллагын хамтран ажиллах Гэрээ
- Соёлын талаар хамтран ажиллах Хэлэлцээр (1957)
- ШУ, техникийн Хэлэлцээр (1961)

<sup>5</sup> Гадаад харилцааны төв архив. х-07, д-01, хн-53, т-207.

<sup>6</sup> Гадаад харилцааны төв архив. х-07, д-01, хн-118.



- Худалдааны удаан жилийн Хэлэлцээр
- Мэдээллийн агентлагийн Хэлэлцээр
- Консулын Конвенци
- Холбооны яамдын хамтын ажиллагааны Хэлэлцээр
- Шуудан солилцох Хэлэлцээр

БНПАУ-ын ГЯЯ-ны 5-р департаментийн хэлтсийн эрхлэгч Л.Абрамович манай ЭСЯ-ны I нарийн бичгийн дарга Х.Санжмятавтай уулзахдаа “тухайн жилийн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн ээлжит чуулганаар “БНМАУ-ыг элсүүлэх асуудлыг” хэлэлцэж магадгүй тул дараахи материалыг бүрдүүлж өгөхийг түүнд хүссэн байдаг. Үүнд:<sup>7</sup>

- БНМАУ-ын түүх, нэн ялангуяа шинэ үеийг илүү тодруулж харуулах
- БНМАУ-ын эдийн засаг, соёлын хөгжилт, ард түмний амьдралын өсөлт, улс ардын аж ахуйг төлөвлөгөөтэй хөгжүүлж ирсэн, ойрын ирээдүйн бүтээн байгуулалт
- БНМАУ-ын гадаад харилцаа хэр хөгжиж ирсэн, олон улсын ямар байгууллагад орж хэр идэвхитэй оролцож ирсэн

БНМАУ-ын асуудлыг НҮБ-ын ЕА-н чуулган дээр удаа дараа хэлэлцэж байсан, чуулганаас ямар нь түдгэлзэхэд хүргэж, ямар нь татгалзахад хүргэж байсан талаар тодорхой бичиж өгөхийг хүссэн байдаг. Энэ нь асуудал “сэтгэл гаргасан” нэг бодит илрэл гэлтэй. БНПАУ-ын Сейм 1957 онд БНМАУ-ыг НҮБ-д элсэхийг дэмжсэн албан бичгээ АИХ-д ирүүлсэн.

1950-1990 онуудад хоёр орны бүх талын харилцаанд МАХН, ПАНН “удирдан чиглүүлэх” үүргээ үлгэр жишээ биелүүлсээр ирсэн. Нэг нь “ардын хувьсгалт”, нөгөө нь “ажилчны нэгдсэн” гэсэн тодотголтой байж хоёул “коммунист” гэсэн нэрийг зүйж яваагүй ч социалист эвслийн коммунист намуудын хэмжээнд бодлого үйл ажиллагаагаа уялдуулан явуулж байсан нь хоёр орны нийгмийн дотоод бүтэцтэй холбоотой аж.

### **Худалдаа, эдийн засаг, техникийн хамтын ажиллагаа**

БНМАУ, БНПАУ нь социалист нэгэн “гэр бүлд” багтан худалдаа,

<sup>7</sup> Гадаад харилцааны төв архив. х-7, д-01, хн-27, х-47.

## ОЛОН УЛС СУДЛАЛ

эдийн засгийн харилцаагаа явуулахдаа “ах дүү”, “гэрэлт ирээдүй”, “улс төр нь сайн бол бусад нь болно” гэсэн зарчимаас ангид байсан нь олон баримтаас харагдаж байна. ПАНН-ын ТХ-ны I нарийн бичгийн дарга В.Гомулка “...бид мөнгө илүүдсэндээ зээл өгөөгүй... зээл бол манай(польш) талын сонирхолд нийцэх ёстой... зээл өгөх замаар бид танайтай хийх худалдааны хэмжээг нэмэгдүүлэх ёстой гэж үздэг”<sup>8</sup> хэмээн монголчуудтай уулзахдаа учирлаж байсан. Цаашлаад хэлэхдээ “Бидний зээл бол танайд үйлдвэр аж ахуйн газар байгуулах, түүгээр танай эдийн засгийг, экспортыг, тухайлбал, Польшид гаргах барааг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм”<sup>9</sup> гэсэн байдаг. Польшууд монголд олгох зээлээ хоёр орны худалдааны эргэлт нэмэгдэнэ гэсэн нөхцөлд л олгоно гэдгээ ч хатуу мэдэгдэж байсан. Польшид нийлүүлэх барааны хэмжээг нэмэгдүүлэхийг шаардахын зэрэгцээ, зээлээ үр ашиггүй шахам, тухайлбал, дэд бүтцийн хөгжилгүй шахуу баруун бүсэд геологи хайгуулын ажил хийлгэхэд зарцуулахгүй байхыг Польшууд мөн л зөвлөж байлаа. Польшийн талын олгож байсан зээл нь 5 жил тутамд 10 сая шилжих рублиэр хязгаарлагдаж байсан. Монголын талын зээлийн төлбөрийг хойшлуулах зарим хүсэлтийг Польш нь “бид өөрөө хөрөнгөтөн орнуудаас жилийн 5-7 хувийн хүүтэй зээл авч байсан ба ЗХУ-аас бүх зүйлээ зээлээр авсан, бусад социалист орнуудаас зээлтэй байгаа” гэдэг шалтгаанаар хүлээн авдаггүй ч үе байлаа.

1970 оны байдлаар Монголын импорт нь Польшийн экспортын 0,1%-г, монголын экспорт нь польшийн импортын 0,2%-г тус тус эзэлж 23 нэрийн бараа гаргаж, 36 нэрийн бараа авах төдийгөөр хязгаарлагдаж байсан ч БНМАУ-ын эдийн засагт “дэмтэй л зүйл” байсан ба ЗХУ-аас авч байсан бараа бүтээгдэхүүнээс харьцангуй хямд байж экспортын үнээ 5-10% нэмээд байх боломжийг манайд олгож байжээ.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцааны үед хоёр орны худалдааны төлөөлөгчид, худалдаа эдийн засгийн хэлэлцээрүүд, зээл эдийн засгийн хамтарсан комисс, Засгийн газар хоорондын комисс зэрэг нь ажлын “голыг нугалж байсан” ч ажлын нийт үр дүн нь 80-90 хувьтай л гардаг байсан.

<sup>8</sup>Гадаад харилцааны төв архив. х-7, д-01, хн-42.

<sup>9</sup> Мөн тэнд

1972 оны 10 сард БНМАУ, БНПАУ-ын хооронд эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн талаар хамтран ажиллах Засгийн газар хоорондын комиссыг хоёр орны СнЗ-ийн орлогч дарга нараар ахлуулан байгуулсан. Монгол, Польшийн худалдаа 1957 онд 2 сая рубль, 1959 онд 9,5 сая рубль, 1960 онд 16,3 сая рубль, 1971-1975 онуудад 30,4 сая рубль, 1976-1980 онуудад 44,6 сая рублийн хэмжээнд байсан<sup>10</sup>. 1970 он хүртэл хоёр улс “БНМАУ-аас БНПАУ-д ба БНПАУ-аас БНМАУ-д бараа нийлүүлэх тухай Ерөнхий Нөхцөл”-ийн ёсоор харилцан бараа нийлүүлж байжээ. 10 зүйл бүхий худалдааны гэрээ нь хоёр улсын Төв банкинд “Клирингийн данс N1” гэж нээж түүгээр дамжуулан гүйцэтгэж байх зэргээр бусад орнуудтай тогтоосон худалдааны Гэрээг бодвол “илүү ажил хэрэгч” шинжтэй байсан. Худалдааны хэмжээгээрээ харьцангуй илүү байсан БНУАУ, БНАГУ-тай хийсэн монголын худалдааны гэрээ нь ердөө 3-5 зүйлтэй л байсан.

Монголоос Польшид нийлүүлсэн барааны бүтцэд 1960 онд төрөл бүрийн ноос 32,5 хувь, арьс шир 10,7 хувь, ангийн үс 2,9 хувь, махан бүтээгдэхүүн 28,8 хувь, 1965 онд төрөл бүрийн ноос 55,9 хувь, арьс шир 5,2 хувь, ангийн үс 4,9 хувь, махан бүтээгдэхүүн 15,1 хувь, арьс ширэн эдлэл 15,6 хувь тус тус эзэлж<sup>11</sup> байв. Польшид өгч байсан махны үнэ нь ЗХУ-д нийлүүлж буй үнээс 10% илүү ч Польшууд монгол махыг реэкспорт хийдэг байсан.

БНМАУ нь зарим үед “экспортын бололцоо хүрэхгүй улмаас” БНПАУ-тай урт хугацаанд харилцан бараа нийлүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ тохирсон хэмжээнд биелүүлж чадахгүй байгаагаа хүлээн зөвшөөрдөг байлаа. Польшийн талаас монголоос авах ноосны хэмжээг ихэсгэх хүсэлт удаа дараа тавьсан ч асуудал дээрхи шалтгааны улмаас эергээр шийдэж байсангүй.

1960 онд БНМАУ-ын Улсын банкны ерөнхий хорооны төлөөлөгчид анх удаа Польшид айлчиллаа.

1970-1980 онуудад буюу ПАНН-ын ТХ-ны I нарийн бичгийн дарга Э.Герексийн удирдлагын үед ч польшууд монголчуудад “эдийн засгийн

<sup>10</sup>Монгол улсын гадаад харилцааны зуун жилийн түүхийн тойм 1911-2011. УБ., 2011. тал 352

<sup>11</sup> мөн тэнд, тал 353



## ОЛОН УЛС СУДЛАЛ

үр ашигтай хамтын ажиллагааны салбарыг хөгжүүлэхийг” санал болгож байв. БНПАУ-ын шууд оролцоотойгоор 1966 онд Улаанбаатар хотод жилд 28,0 мянган куб хөнгөн бетон үйлдвэрлэх завод, Дарханд жилд 25 сая цагаан тоосго, 22,0 мянган тн шохой шатаах хүчин чадалтай завод, 1968 онд Мод боловсруулах үйлдвэрийн зүсмэлийн цех, 14 аймагт тоосгоны заводын засварын газар болон лабораторийн бүрэн төхөөрөмж нийлүүлсэн, 1970 онд Хархорины цахилгаан станц, 1971 онд Улаанбаатарын мод боловсруулах үйлдвэр, 1974 онд Хархорины спиртын үйлдвэр, 1976 онд Улаанбаатарын Халиман цавууны үйлдвэр, 1979 онд Ноосны үйлдвэрийн эрдэм шинжилгээ, туршилтын төвүүдийг барьж байгуулжээ. 1988 онд Нэхээсгүй давууны үйлдвэр Улаанбаатарт байгуулжээ.

Монголын ХАА-н гол салбар болох мал аж ауйн үйлдвэрлэлийн салбарт хамтын ажиллагаа өргөн байлаа. 1966-1968 онуудад 40-50 хүний бүрэлдэхүүнтэй мал эмнэлгийн отрядыг Төв, Дундговь аймагт ажиллуулж 4,2 сая толгой малд халдварт өвчний шинжилгээ хийсэн. 1969 онд ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудаас мал эмнэлгийн экспедицийг Монголд ажиллуулсан ба Польшийн мэргэжилтэнүүд оролцлоо. Тухайлбал, 1971-1978 онд Польшийн мал эмнэлгийн 14 лаборатори, оношлох 90 кабинетыг иж бүрэн төхөөрөмжөөр тоногдсон ба олон тооны мэргэжилтнээ ажиллуулж байлаа. Польшууд монголоос авах махны шинжилгээг өөрсдөө ирж хийх шаардлага тавьж байсан бол бусад социалист орнууд монголын талын шинжилгээний дүнгээр хүлээн авдаг байлаа. Польшийн мал эмнэлгийн хууль, журам Европт хамгийн хатууд тооцогддог бөгөөд мал, мах болон боловсруулалт хийгдээгүй мал аж ахуйн гаралтай түүхий эдийг Монголоос импортлох зөвшөөрөл олгохыг 1989 оноос эхэлж зогсоох шийдвэр гаргажээ.

### Соёл, урлагийн хамтын харилцаа

БНМАУ, БНПАУ-ын соёл, боловсрол, шинжлэх ухааны хамтын ажиллагаа нь социалист системийн “нүүр царай”, “нэгдэл, нягтралын” илрэл тул нэлээд амжилттай сайн хөгжсөн хэмээн үзэж болно. 1953 оны 7 сард 10 хоногийн туршид Польшийн дуу бүжгийн “Мазовце” хамтлаг 146 хүний бүрэлдэхүүнтэй ирж 5 удаа тоглолтоо хийсэн.



Энэ нь монголын түүхэнд тийм том бүрэлдэхүүнтэй гадаадын урлаг, соёлын баг ирсэн анхны тохиолдол болов уу. Зөвлөлтөөс ч тийм баг хараахан ирээгүй л байсан үе. Польшийн нэрт хөгжмийн зохиолч Ф.Шопены нэрэмжит олон улсын төгөлдөр хуурчдын V уралдаанд монголчуудыг оролцохыг урьсан урилгаа Польшийн соёл, урлагийн сайд нь 1954 онд ирүүлсэн ч монголын тал Москвагийн консерваторт сурч байсан Мөрдоржийг “түүгээр нь ажиглагчаар оруул” гэсэн шийд гаргаж байв. 1960 оны 2 сарын 22-нд Фредрик Шопены 150 жилийн ойг 4-5 арга хэмжээний хүрээнд БНМАУ-д тэмдэглэсэн ба “Үнэн” сонинд Г.Бирваагийн “Ф.Шопен” хэмээх нийтлэл гарч, “Утга зохиол” сонинд Ф.Шопений тухай томоохон хөрөг нийтлэл<sup>12</sup> ч гарсан байдаг.

1958 оны 12 сарын 23-нд Монгол-Польшийн хооронд соёлоор хамтран ажиллах хэлэлцээр анх байгуулагдсан ба тэр нь 1968 оноос таван жилээр автоматаар сунгагдаж байхаар болсон. Монгол, Польшийн хоорондын соёл, гэгээрлийн хамтын ажиллагаа жил бүр гаргаж баталсан төлөвлөгөөний дагуу явагдаж байсан. Польшийн Үндэсний баярыг Монголд тэгш ойтой жилд улс орон даяар өргөн хэмжээнд тэмдэглэж улсын наадмаар БНМАУ-ыг сурталчлах ажлыг БНПАУ-д өргөн хүрээтэй явуулдаг болсон байна. Монгол киног польш хэл рүү орчуулан польш үзэгчдэд хүргэх ажил ч хийгддэг болсон. Польшид монголын уран бүтээлчдийн үзэсгэлэнг гаргах болсон. Польшийн зохиолчдын зохиол бүтээлүүд нь намын цензурт нийцсэн тохиолдолд монгол хэл рүү хөрвүүлэн нийтийн хүртээл болгож байсан ба зарим нь хэвлэх үйлдвэрээс буцаан татагдсан тохиолдол ч гарч байлаа.

Монголын цэргийн баяраар Польшийн цэргийн анги, нэгтгэл дээр соёл, урлагийн номер үзүүлдэг, музейд нь үзмэрүүд, цэргийн төв хэвлэл дээр нь мэдээ, нийтлэгддэг байжээ.

Хоёр орны хооронд Намын Төв Хороо, Үйлдвэрчний Эвлэлийн Төв Зөвлөл, Батлан Хамгаалах Яамдын төлөөлөгчдийг харилцан амрааж, танилцах аялалыг зохион байгуулдаг байсан. Тухайлбал, 1963 онд нийтдээ 524 жуулчин БНМАУ-д ирснээс БНПАУ-аас 60 жуулчинг 12 хоноогоор хүлээн авсан. Монголоос Польш, Германд жилд 20 хүнийг аялуулдаг болсон.

<sup>12</sup> Утга зохиол сонин, 1960.2.25-ны дугаар.

## ОЛОН УЛС СУДЛАЛ

1984 оноос хоёр орны харилцаа хэвийн байдалдаа эргэн шилжиж 1984 онд Польшийн соёлын өдрүүд Улаабаатарт, 1985 онд Польшид “БНМАУ” үзэсгэлэн зохиогдов.

### **Боловсрол, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагаа**

Зүүн Европын социалист орнууд 1950-иад оны эхээр монголчууд суралцаж эхэлсэн ба 1990-ээд он хүртэл монголын олон зуун залуучууд суралцаж төгссөн билээ. Тэнд суралцаж байсан оюутны сурлага, хүмүүжлийн асуудлыг тухайн орон дахь манай ЭСЯ хариуцан сурлага, хүмүүжилд нь анхаарч байсан. Зөвхөн Польшид төдийгүй нийтдээ гадаадад сурч байсан монгол оюутнууд сурлага, хүмүүжлийн талаар хэл ам их дагуулдаг байсан нь нэг талаас “соёлын шок”, нөгөө талаас “бие даасан байдал” харьцангуй дутмаг байсантай холбоотой болов уу. Энд нэлээн олон хүчин зүйл байсныг бодох ёстой.

1956 оноос анхны хоёр монгол оюутан Польшид сурахаар явсан. Польш улс нь буцалтгүй тусламжийн хүрээнд монголын оюутан, аспирантуудыг сургах, монголчуудын үйлдвэрлэлийн дадлагыг хийлгэхээс гадна Польш мэргэжилтнүүдийн зардлын зарим хэсгийг санхүүжүүлж байлаа. Варшавын их сургуулийн монгол хэлний ангид монголоос багш авч ажиллуулдаг байсан ба 1990 он хүртэл тэнд монгол хэлний багш ажиллаж байлаа.

1964-1965 оны хичээлийн жилээс эхлэн БНПАУ-ын талаас 20 монгол оюутанг өөрийн зардлаар сургахаар, монголын талаас 2 польш оюутанг сургахаар тус тус шийдсэн ба тухайн жилд 41 монгол оюутан сурч байсны 35 нь польшийн зардлаар сурч байлаа. 1950-1990 онуудад БНПАУ-д нийт 200 шахам монгол залуучууд дээд боловсрол эзэмшсэн ба мэргэжлийн сургалт үйлдвэрлэл, техникум, дадлагажих курст олон зуун залуус суралцаж төгссөн.

1960 оны хэлэлцээрээр БНПАУ-аас 11 төрлийн мэргэжлийн 40 инженер 2-3 жилийн хугацаагаар Зургийн институт болон Барилгын яаманд ажиллахаар болсон байдаг. Польшийн тал Монголд ажиллах хүч явуулахад татгалзах зүйлгүй гэдгээ ч мэдэгдэж байлаа. 1969 онд Польшийн 150 гаруй мэргэжилтэн Монголд ажиллаж байсан. Польшоос

өрлөгчин, шаварчин, мужаан, бетоны арматурчин, цахилгаанчин авч ажиллуулан тэднийг дагалдуулан монголчуудыг сургаж байв.

1961 онд ШУТ-ийн талаар хамтран ажиллах хэлэлцээр байгуулагдсан. 1963-1965 онуудад монгол-польшийн палеонтологийн хамтарсан экспедици ажиллаж 11 динозаврын яс олсон. Манай Академиудын хоорондын хамтын ажиллагаанд Палеонтологи, Угсаатны зүй, Философийн чиглэлээр ажиллаж байсан нь Монголд “өгөөж багатай” дан польш талын сонирхлоор хийгдэж байсан юм шиг санагдсан.

БНПАУ нь 1986-1990 онд монголд хоёр орны шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд 7,9 сая шилжих рублийн, 204 сая злотын буцалтгүй тусламж<sup>13</sup> үзүүлэхээр шийдсэн. Энэ 7,9 сая нь үндсэндээ геологийн экспедицийн польшийн талын зардалд, зам, барилгын эрдэм шинжилгээний лабороторийг тоноглоход зарцуулахаар болов. Тусламжийн 204 сая злотыг 10 аспирант, 25 оюутан, 600 хүний дадлагад зориулахаар болсон. Монголчууд зээлээ бүрэн ашиглаж чаддаггүй, квотод нь хүргээд оюутнаа явуулж чаддаггүй тохиолдол элбэг байлаа.

Монгол судлалд польшийн эрдэмтэд, судлаачид зохих хувь нэмрээ оруулсаар ирсэн. Польшийн иргэн С.Койло нь 1973 онд “капиталист бус хөгжлийн замаар социализмд орж буй БНМАУ-ын хувьсгалт өөрчлөлтүүдийн үе шат” сэдвээр докторын зэрэг хамгаалсан тэрээр сүүлд Монголын “Тавантолгойн” ордыг ашиглах талаар “тун боломжийн зөвлөгөө” өгч байсан хүний нэг. 1975 онд БНПАУ-ын Төрийн Зөвлөлийн даргын айлчлалын үеэр дэлхий нийтээрээ өргөн тэмдэглээд 2 жил өнгөрсөн ч “нарыг зогсоож, дэлхийг хөдөлгөсөн хүн” польш эрдэмтэн Н.Коперникийн 500 жилийн ойг тохиолдуулан эрдэмтний цээж хөшөөний нээлтийг Улаанбаатар хотод хийв.

### **Найрамдлын нийгэмлэгүүдийн үйл ажиллагаа**

БНМАУ, БНПАУ-ын харилцааны талаархи сургалчилгаа, ойлголцол, танин мэдэхүй, цар хүрээ, ардын дипломат зэрэгт бодит

<sup>13</sup> Гадаад харилцааны төв архив. х-7, д-01, хн-117.



## ОЛОН УЛС СУДЛАЛ

хувь нэмэр оруулсан байгууллага бол хоёр орны найрамдлын нийгэмлэгүүд билээ. Төрийн дээд хэмжээний айлчлалын үеэр хоёр талын зочид хөдөлмөрчдийн цуглааныг хийдэг, тэр цуглаанд хоёр орны Найрамдлын нийгэмлэгийн гишүүд, идэвхтнүүд идэвхитэй оролцож үйл ажиллагаанд “хүч нэмэгдүүлдэг” байлаа. 1960 онд Монголд “Монгол-Польшийн найрамдлын нийгэмлэг” байгуулагдаж даргаар нь ШУА-ийн ерөнхийлөгч Б.Ширэндэв ажиллах болсон. 1974 он гэхэд МПНН нь 1000 гаруй гишүүдтэй болсон. Төв аймгийн Баян сумын “Цацралт” нэгдэл нь “монгол-польшийн найрамдал”-ын нэрэмжит болж улмаар Польшоос ирсэн зочид, төлөөлөгчдөд үзүүлэх, танилцуулах газрын нэг болсон. Тухайн сум, нэгдлийн төлөөллийг ч Польшид зочлуулдаг байв.

1970 оны 1 сарын 23-нд БНПАУ-д Монголыг дэмжих, сурталчилан таниулах зорилго бүхий “Польш-Монголын найрамдлын бүлгэм” хэмээх 90 шахам гишүүнтэй олон нийтийн байгууллага байгуулагдан даргаар нь Монголд Элчин сайд байсан ба тухайн үедээ БНПАУ-ын Хөнгөн үйлдвэрийн яамны орлогч сайдаар ажиллаж байсан В.Какэтэк сонгогдсон. Уг байгууллага нь ПАНН-ын Төв Хорооны шийдвэрээр ДЯЯ-ны тусгай зөвшөөрлөөр байгуулагддаг бөгөөд тухайн үед тийм байгууллага болох Польш-Зөвлөлт, Польш-Хятад, Польш-Энэтхэгийн бүлгэмүүд л зөвшөөрөгдөн ажиллаж байсан. Энэхүү бүлгэм нь цаашид “нийгэмлэг” болох зорилт тавин ажиллаж эхэлсэн. 1970 оны 5 сарын 24-нд БНПАУ-ын Чеханов мужийн Воля Млоцка ХАА-н хоршооллыг “польш-монголын найрамдлын нэрэмжит” болгов. 1986 онд Тарнов мужийн Дембице хотын ХАА-үйлдвэрийн “Иглоопаль” комбинатын ажилчид хамт олноороо ПМНН-т элсэж байв.

Польшууд БНМАУ-ыг сурталчилахдаа “ЭЗХТЗ-ийн орнуудын анхаарлыг татаж байгаа БНМАУ нь ЭЗХТЗ-ийн орнуудыг түүхий эдээр бүрэн хангаж чадах асар их баян орон бөгөөд газар нутаг, хүн ам цөөн, техник бүрэн нэвтэрч чадаагүй улмаас түүнийг бүрэн нээж ашиглаж чадаагүй байна” гэсэн фразыг өргөн ашигладаг байв. Варшав, Улаанбаатар хотууд хамтын ажиллагааны “тохиролцоотой” байснаас гадна Дархан хот Ополе воеводство-той шууд харилцаатай байсан.

Монгол, Польшийн харилцааны түүхийн “дурсгалтай” үйл явдлын

нэг бол харилцан “шагнаж, урамшуулах процесс” байсан. 1971 онд Монгол ардын хувьсгалын 50 жилийн ойгоор Польшийн 125 хүнийг төрийн дээд одон, медалиар шагнажээ. 1975 онд Төрийн Зөвлөлийн даргын айлчлалын үеэр монголын талын 34 хүнийг польшийн төрийн дээд шагналаар, польшийн талын 33 хүнийг монголын төрийн дээд одон медалиар шагнажээ. Хоёр орны харилцааг өргөтгөн хөгжүүлэхэд хүч сэтгэл гаргасан Польшийн олон элчин сайдыг Монголын төрийн дээд шагналаар шагнасан.

### **Хүмүүнлэнгийн хамтын ажиллагаа**

1966 оны 7 сарын үерийн гамшгийг даван туулахад БНПАУ-аас 5000 тн цемент, 100 киловаттын хүчтэй 100 ширхэг цахилгаан мотор, ус сорогч шахагч хөөрөг, 25 метрийн урт лент бүхий транспортер, шавардагч машин, слесарийн бүрэн багаж 500 ширхэг, эм антибиотик 16700 ширхэг, 100000 злотын будаг шунх зэргийг буцалтгүй тусламжаар олгов<sup>14</sup>. 1981 оны Онц байдлын үеэр БНМАУ “сэтгэл санаа” нэгтэй байж 2000 тн<sup>15</sup> мах нийлүүлж туслав.

### **Дүгнэлт**

Энэ 40 жилд БНПАУ-ыг В.Гомулка, Э.Герек, В.Ярузельский гээд “социалист хамтын нөхөрлөл” гэхээсээ илүү “үндэсний шинжтэй социализм” байгуулах бодолтой хүмүүс удирдаж байсан явдал нь нэгд, ЗХУ-ын “хамгийн дотно түнш” БНМАУ-тай харилцах харилцааг хурдацтай өргөн явуулах тэдний “хүслийг бадраасангүй”, хоёрт, Польшид нэн шаардлагатай хөрөнгө, техник технологи бидэнд байсангүй, түүхий эдээ ч хүссэнээр нь гаргаад байх “чадал” байгаагүй, гуравт, “явж суухад ч дэндүү алслагдмал” учраас хамтын ажиллагаа жинхэнэ утгаараа далайцтай болж чадаагүй.

БНМАУ-ын хувьд улс төрийн ач холбогдолтой төдийгүй Европын соёлд “түн орох” үүдийг нээсэн БНХАУ-тай худалдаа, эдийн засгийн харилцаа зогсонги болсон үед түүнийг зохих хэмжээнд нөхөх боломж

<sup>14</sup> Гадаад харилцааны төв архив. х-07, д-01, хн-45.

<sup>15</sup> Гадаад харилцааны төв архив. х-07, д-01, хн-94.

## ОЛОН УЛС СУДЛАЛ

олгосон харилцан ашигтай арилжаа хийх аргад суралцсан гээд тоочвол эерэг зүйл их.

Монголчуудын хувьд хоёр системийн сэргэлдөөний талаар болон нийгэм дэхь олон ургальч санаа бодол, ажил хаялт, жагсаал цуглаан, ухуулга хуудас бичих, тараах, уриа лоозон хатгах талаар ч тэднээс зохих хэмжээнд суралцсан.

1956 оны Унгар, 1968 оны Чехословак, 1970, 1980 оны Польшийн үйл явдлууд нь ЗХУ-ын улс төр, эдийн засгийн чадавхи хэвээр хүчтэй байгаа нөхцөлд системийг өөрчлөх санаа “бүтэшгүй” гэдгийг харуулсан бөгөөд Өрнөдөөс үзүүлэх тусламж, дэмжлэг нь нөхцөл байдлыг зөвхөн “өдөөх” хэмжээнээс хэтэрч чадахгүй байсан. Зөвхөн 1981 оны улс төр, эдийн засгийн хүндрэлтэй холбогдуулан ЗХУ-аас БНПАУ-д 4 тэрбумын тусламж үзүүлсэн байдаг. Харин “системийн мотор” доголдолд ороод, ажиллахгүй болсон үед гадны онц нөлөөгүйгээр системийн задрал явагдсан ба энэ нь 1990 онд Польшид ч, Монголд ч илүү тод мэдрэгдсэн. Энэ 40 жилд Өрнөдийн орнуудаас 10 гаруй сая польш иргэдтэй АНУ, Польшийн “гадаад дахь Засгийн газар нь товхиносон” Их Британи хоёр Польшийн асуудалд онцгой “анхаарал тавьсаар” байсан. 1981 оноос авсан АНУ-ын эдийн засгийн хориг арга хэмжээний дараагаар Польшийн “Үйлдвэрчинд” жил тутам 1 сая ам.долларын санхүүгийн тусламж үзүүлэхээр АНУ-ын Конгресс шийдсэн байдаг.

Бидний найрамдлын 40 жил социалист системийн “зүүн, баруун хилийн манаанд” БНМАУ, БНПАУ “хамтран зогссон” он жилүүд байлаа.

### Ном зүй

1. Үндэсний төв архив, МАХН-ын баримтын төв
2. ГХЯ-ны төв архив
3. Монгол улсын гадаад харилцааны зуун жил түүхийн тойм 1911-2011. Улаанбаатар хот 2011.